Харилцагч: . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .

Код: 13190619

тлр:ПҮРЭВДОО.ГАНЗУЛ(1757)/1049 (1073)

Төрийн банк

ТӨРИЙН БАНК

**МЕМОРИАЛЫН БАРИМТ № 20170309625700437834 - 0**

Банк хоорондын гүйлгээ

2017.02.17

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Дебит | 1060 - ТБ БАЙГУУЛЛАГЫН БАНК | | | | | |
| | АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР | | | | | |
| | DP | 340004010398 | зарлага | ***************2,279.13 | USD | 2,472.00 |
| Кредит | 150000 - Голомт төв банк - Голомт төв банк | | | | | |
| | ДАВААСҮРЭН | | | | | |
| | BA | 2209226524 | | ***************5,634,000.00 | MNT | 1.00 |

Гүйлгээний дүн (үсгээр) *хоёр мянга хоёр зуун далан есөн доллар арван гурван цент*

Гүйлгээний утга: ОРЧУУЛГЫН ХӨЛС

Теллер: . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .

ТЕЛЛЕР 429

Нох оne хийсэв
2017.03.09

**Авлигатай тэмцэх газарт**

Нэхэмжлэх

Миний бие Ч.Даваасүрэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан авлигатай тэмцэх гарын авлагыг орчуулах ажил үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж, орчуулгыг хүлээлгэн өгөөд байгаа билээ.

Иймд гэрээнд заасны орчуулгын ажлын нийт хөлс болох 6,260,000 (зургаан сая хоёр зуун жаран мянган) төгрөгийг үүгээр нэхэмжилж байна. Төлбөрийг миний Голомт банкны 2209226524 тоот дансанд шилжүүлэхийг хүсье.

Орчуулагч: Ч.Даваасүрэн

2017 оны 2 дугаар сарын 08-ны өдөр.

БАТЛАВ.
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР З.БААСАННЯМ

**ОРЧУУЛГЫН ГЭРЭЭ**

**№ 119.**

*2016 оны 10 сарын 05-ны өдөр* *Улаанбаатар хот*

Энэхүү гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын Иргэний хуулийн 32-р бүлгийг үндэслэн,

Нэг талаас “Авлигатай тэмцэх газар” /цаашид “А” тал гэнэ/, нөгөө талаас бичгийн орчуулагч РЮ80120210 регистрийн дугаартай Чулуунбат овогтой Даваасүрэн /цаашид “Б” тал гэнэ/ /хамтад нь “*Талууд*” гэнэ/ нар харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.
## ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗҮЙЛ

1.1 Б тал нь “Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан авлигатай тэмцэх гарын авлага”-ын бичгэн орчуулга хийж үйлчлэх бөгөөд энэхүү Гэрээ нь ажлын зохих хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

1.2 Б тал нь Гэрээнд заасан ажлыг гэрээнд заасан болзол, нөхцөл ба тохиролцсон хөлсөөр гүйцэтгэх, А тал нь Б талын ажил үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангаж, Гэрээгээр тохиролцсон хөлс олгох нь энэхүү Гэрээний гол зүйл мөн.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ.
## ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд Б талын хариуцан хийх ажил дуусгавар болгох өдөр буюу 2016 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Гэрээ дуусгавар болно.

2.2 Гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт заалтуудыг хавсралтаар оруулж болно.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ.
## АЖЛЫН ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ, ХЭЛБЭР, ОЛГОХ ЖУРАМ

3.1 А тал Б талд дараах хөлсийг олгоно:

“Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан авлигатай тэмцэх гарын авлага”-ын бичгэн орчуулгын гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 6,260,000 /зургаан сая хоёр зуун жаран мянган/ төгрөг байна. (Үүнд: Орчуулагчийн нийт орчуулах ёстой материалын хэмжээ 689.610 ширхэг тэмдэгт. Нэг хуудаст багтах тэмдэгтийн хэмжээ нь 2,200 тэмдэгт. Орчуулах материал нь ын 313 хуудас, нэг хуудас орчуулгын ажлын хөлс 20,000.00 төгрөг. Иймд: 313 хуудас x 20,000.00 = 6,260,000.00 төгрөг)

3.2. Дээрх дүнд хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл болон хуульд заасан бусад татвар хураамж орсон болно.

3.3. Ажлын хөлсийг Б талын нэр дээрх дараах дансанд шилжүүлнэ: Голомт банкин дахь төгрөгийн /2209226524/ тоот данс.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.**
**А ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1 А тал нь дараах эрх, үүрэгтэй:

1. Б талд энэхүү Гэрээгээр тохирсон хөлс олгох

**ТАВДУГААР ЗҮЙЛ.**
**Б ТАЛЫН ЭРХ,ҮҮРЭГ**

5.1 Б тал нь дараах эрх, үүрэгтэй:

1. Энэхүү Гэрээнд заасан ажил үүргийг бүрэн хариуцаж хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэх
2. А талын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийн нууцыг чандлан хадгалах бөгөөд өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ**
**БУСАД ЗҮЙЛ**

6.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахад Талууд тэгш эрх эдэлж, оруулсан нэмэлт, өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй болно.

6.2 Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.4 Гэрээг 2 хувь үйлдэж А тал ба Б тал тус бүр 1 хувийг хадгална.

**<u>ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:</u>**

**А ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

АТГ-ны США-ны ажилтан
Б.Баярсайхан

........................................................................
/гарын үсэг/

**Б ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

Орчуулагч Ч.Даваасүрэн

........................................................................
/гарын үсэг/